



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2023 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам
(САИНН)-ыг улсын бүртгэлд бүртгэж,
улсын бүртгэлийн гэрчилгээ олгох тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч М.Батсуурийн танилцуулснаар хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дарга Б.Жагараас “Монгол Улсын нэр бүхий иргэд бид Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан эвлэлдэн нэгдэх эрхийн дагуу 2021 оны 12 дугаар сарын 12-ны өдөр нам үүсгэн байгуулсан бөгөөд Монгол Улсын дээд шүүхээс манай намын өргөдөл, бичиг баримтыг 5 удаа хэлэлцэн, хуулийн шаардлагыг зөрчсөн үндэслэлээр буцаасан. Намын зүгээс 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдөр нам үүсгэн байгуулах Их Хурал хийж, нийт шүүгчийн өгсөн үүрэг, 39 дүгээр тогтоолд заасан зөрчлийг арилган бүртгүүлэхээр өргөдөл, бичиг баримтыг дахин хүргүүлж байгааг хүлээн авч хэлэлцэн, улсын бүртгэлд бүртгэж өгнө үү” гэжээ.

Тухайн нам үүсгэн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг 5 удаа шүүхэд ирүүлснийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 03, 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 14, 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 20, 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 30, 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор тус тус хангахгүй орхиж, улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН) нь 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдөр нам үүсгэн байгуулах Их Хурлаа зохион байгуулж, Хурлын Төлөөлөгчдийн 05 дугаар тогтоолоор “... Үндсэн хууль болон Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулсан намын дүрэм”-ийг хавсралтаар баталж, улсын бүртгэлд бүртгүүлэхээр шийдвэрлэсний дагуу тус намын дарга Б.Жагараас 2023 оны 02 дугаар сарын 27, 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдөр дахин шүүхэд хандан, өргөдөл, түүнд холбогдох баримтыг хавсаргаж ирүүлжээ.

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батлагдсан Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын 3.1-д заасны дагуу шүүгчээс тус намын өргөдөл, түүнд хавсаргасан баримт нь бүрдэл хангасан эсэхийг 5 хоногийн дотор шалгаж, журмын 3.5.5-д заасан "... Намын гишүүдийн өөр намын харьяалалгүй болон бусдаар төлөөлүүлээгүй тухай нотломжийг энэ журмаар баталсан загварчлалын дагуу бэлтгэж, хавсаргасан байвал зохино" гэснийг зөрчиж, журмын хавсралтаар батлагдсан №1А маягтын 4.13-т заасан гишүүний нотломжийг ирүүлээгүй, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 39 дүгээр тогтоолд дурдсан зарим зөрчил арилсан эсэх нь эргэлзээтэй үндэслэлээр 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 04/730 дугаар албан бичгээр баримт бичгийн мэдээлэл, бүрдэл хангаж ирүүлэх хугацааг 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийг дуустал тогтоосон.

Тус намын дарга Б.Жагараас "намын нэг гишүүн эрүүл мэндийн шалтгаанаар цаашид намын үйл хэрэгт оролцох боломжгүй болсон тул чөлөөлөгдсөн гишүүний оронд өөр гишүүн нөхөн оруулах", мөн "намын нэг гишүүн нас барсан тул өөр гишүүнийг бүртгүүлэх, гишүүдийн бүртгэлд цөөн хүний мэдээлэл алдаатай бичигдсэн тул засах боломж олгохыг хүсэж" гаргасан өргөдөл, холбогдох материалаа татан авах хүсэлтүүд гаргасныг шүүхээс хангаж, 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн өргөдлийг Улсын дээд шүүхийн 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 04/780, 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн өргөдлийг Улсын дээд шүүхийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 04/1032 дугаар албан бичгээр тус тус буцаасан байна.

Үүний дараа "... алдаа зөрчил арилсан" гэх үндэслэлээр 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр нам үүсгэн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг дахин гаргаж, 3 хавтас, 1604 хуудас (сиди 4, флаш-1) бүхий баримт хавсаргаж ирүүлснийг шүүх хүлээн авч, Улс төрийн намын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон Улс төрийн намын бүртгэл хөтлөх журамд заасан шаардлага хангасан эсэхэд нягтлан шалгах ажиллагааг явуулж, 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанд танилцуулсны үндсэн дээр Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ыг үүсгэн байгуулах Их Хурлыг 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдөр танхимын хэлбэрээр зохион байгуулж, тус намын дарга Б.Жагараас 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг Улсын дээд шүүхэд гаргасан нь Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасанд нийцсэн, өргөдөл, түүнд хавсаргасан баримтууд нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасан шаардлагатай мэдээллүүдийг бүрэн агуулсан байна.

Нэг. Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын 3.8-д "Нам үүсгэн байгуулсныг бүртгүүлэхээр шүүхэд хандсан боловч шүүхээс тухайн намыг бүртгэхээс татгалзсан, тухайлбал намын гишүүдийн тоо хуульд заасан тоонд хүрээгүй, намын дүрэм хуульд нийцээгүй, нам үүсгэн байгуулах хурал журмын дагуу хуралдаагүй бол нам үүсгэн байгуулах хуралдааныг хууль, журамд нийцүүлэн дахин зохион байгуулсан тухай баримтыг ирүүлнэ" гэж тус тус заасан.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор "... хурлыг нээлттэй үлдээх болон намын батлагдсан дүрэмд орсон нэмэлт өөрчлөлтийн асуудал нь "нам үүсгэн байгуулагдсаныг улсын бүртгэлд бүртгэсэн" тохиолдолд буюу бүртгэсний дараа хийгдэх ажиллагаа бөгөөд нэгэнт нам улсын бүртгэлд бүртгэгдээгүй, өөрөөр хэлбэл, улсын бүртгэлийн гэрчилгээ байхгүй, намын дүрэм Улсын дээд шүүхэд хянагдаж албан ёсоор хүчин төгөлдөр болоогүй байхад дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж батлах хүртэл хурлыг нээлттэй үлдээх асуудал байх боломжгүй, ... үүсгэн байгуулах Их Хурлыг өмнөх Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоол гарсан өдрөөс хойш 25 хоногт буюу 2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хуралдуулсан ..." гэсэн үндэслэлээр тус намын өргөдлийг татгалзаж байсан.

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын Мандатын комиссоос 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн №244 (6976) дугаар бүхий Зууны мэдээ сонинд "Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намыг үүсгэн байгуулах Их Хурал 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 12:00 цагт хуралдана. Хурлаар Монгол Улсын дээд шүүхийн 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн нийт шүүгчийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлтийг хангах зорилгоор, улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдуулан намын дүрэмд засвар, нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн батална. Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын аймаг, нийслэл, сум, дүүргийн гишүүд та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна. Монголын Залуучуудын холбооны хурлын танхимд хурал болно" гэж нийтэд мэдээлсэн; мөн өдөр тухайн намын фэйсбүүк группээр дээрх хурлын товыг зарласан, намын гишүүд, төлөөлөгч нарт мэдэгдсэн болох нь утсаар ярьсан тэмдэглэл, сонин, тогтмол хэвлэлүүдийн мэдээллээр хангах үйлчилгээний орлогын ордер тасалбар, заалны түрээсийн төлбөр төлсөн бэлэн мөнгөний орлогын баримт болон бусад баримтаар тогтоогдож байна.

Өөрөөр хэлбэл, дээрх 39 дүгээр тогтоол гарсан өдрөөс хойш 66 дахь хоногт 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдөр тус намын үүсгэн байгуулах Их Хурлыг хуралдуулсан нь Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Намыг үүсгэн байгуулах хурлын бэлтгэлийг урьдчилан хангах ба зохион байгуулж явуулах газар, хугацааг 2 сарын өмнө төлөөлөгчдөд мэдэгдсэн байна" гэж заасныг зөрчөөгүй, өмнөх тогтоолд заасан зөрчил арилсан байна.

Хоёр. Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дүрмийн 6.4-т "Намын Их Хурал нь 51 ба түүнээс дээш сондгой тооны сонгогдсон болон томилогдсон төлөөлөгчдөөс бүрдэх буюу тэдгээрийн гуравны хоёроос багагүй төлөөлөгч хүрэлцэн ирснээр намын Их хурлыг хүчинтэйд тооцно" гэж заасан; тухайн намын үүсгэн байгуулах Их Хурлын 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Их Хурлын төлөөлөгчдийн бүрэн эрхийг баталгаажуулсан ба Мандатын комиссын илтгэл болон хурлын тэмдэглэлд "хуралд оролцохоо мэдэгдсэн 90 төлөөлөгчөөс 75 төлөөлөгч оролцсон" гэж, хуралд оролцсон төлөөлөгчдийн ирцийн бүртгэлд бүртгэгдсэн 90 төлөөлөгчөөс 75 гишүүн гарын үсэг зуржээ.

Шүүхээс хуралд оролцсон гэх дээрх 75 төлөөлөгчийг тус намын 801 гишүүний бүртгэлийн нэрстэй тулган үзэхэд төлөөлөгчийн бүртгэлийн 23, 24 дугаарт бичигдсэн П.Эрдэнэцогт, Ч.Даваахүү нарын нэрс гишүүдийн нэрсийн жагсаалтад байгаагүй, энэ талаар шүүхээс сонсох ажиллагаа явуулахад тухайн намын дарга Б.Жагараас "... манай ажилтны буруугаас болж хасагдах жагсаалтад орсон хоёр

хүнийг хасаагүй, үндсэн 2 гишүүнийг хасаж алдаа гаргасан ..." гэх, мөн П.Эрдэнэцогт, Ч.Даваахүү нараас "тухайн намын гишүүн мөн" гэх тайлбарыг тус тус баримтын хамт ирүүлснээс гадна Ч.Даваахүү нь редакцын комиссын гишүүнээр ажиллаж, холбогдох тогтоолуудад гарын үсэг зурсан, хуралд оролцсон байх тул шүүхээс эдгээр төлөөлөгчийг тус намын гишүүн мөн гэж үзлээ.

Хэдийгээр тус намын үүсгэн байгуулах Их Хуралд 75 төлөөлөгч оролцсон гэж тэмдэглэсэн байх боловч шүүхээс 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хурлын бичлэгийг шалгахад тухайн хуралд 51 төлөөлөгч оролцсон байх бөгөөд энэ талаар сонсох ажиллагаа явуулахад тухайн намаас 51 төлөөлөгч оролцсон болохыг хүлээн зөвшөөрч, холбогдох тайлбар, баримтуудаа шүүхэд ирүүлсэн болно.

Намын дүрмийн дээр дурдсан заалтаар 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн нам үүсгэн байгуулах Их Хуралд нийслэл, дүүрэг, орон нутгийн төлөөлөл бүхий 51 төлөөлөгч оролцсоноор тухайн хурлыг хүчинтэйд тооцох бөгөөд энэ нь мөн Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.3-т заасныг зөрчөөгүй байна.

Гурав. Улс төрийн намын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т "Монгол Улсын иргэн зөвхөн нэг намын харьяалалтай байна", 9 дүгээр зүйлийн 9.3.7-д "намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл /овог, эцгийн болон өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, гарын үсэг/;" гэжээ.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 39 дүгээр тогтоолын үндэслэлд "... тохиолдлын журмаар түүвэрлэн 343 иргэний мэдээллийг нягтлан шалгахад: тухайн намын гишүүн биш гэх 19, давхар намын харьяалалтай гэх 7, сонгуулийн эрх бүхий 18 насанд хүрээгүй 2, холбогдох утсан дээр байхгүй 18 иргэн байхаас гадна гишүүдийн гар бүртгэл, файлын бүртгэл нь хоорондоо зөрүүтэй, зарим иргэдийн иргэний үнэмлэхийн хуулбар байхгүй, дутуу, мэдээлэл уншигдахгүй бүдэг, ургийн овог, нэр, алдаатай, хаягийн мэдээлэл нь иргэний үнэмлэхийн хуулбараас зөрүүтэй гэх мэт зөрчлүүд илэрсэн ..." талаар дурдсан.

Шүүхээс Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дарга Б.Жагарын өргөдөлдөө хавсарган ирүүлсэн 801 гишүүдийн мэдээлэл нь хууль болон журамд заасан шаардлага хангаж буй эсэхийг тодруулахаар 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газарт хандахад 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 9/2388 дугаар албан бичгээр 139 гишүүний мэдээлэл зөрүүтэй /үүнээс нас барсан-1, ургийн овгийн үсэг зөрсөн-10, эцэг эхийн нэр зөрсөн-5, регистрийн дугаар буруу-4, регистрийн дугаар үсэг зөрсөн-1, хаягийн зөрчилтэй (хаалганы дугаар, баг, хороо зөрсөн гэх мэт) – 118/ болох нь илэрсэн; тус намын даргаас тухайн алдаа зөрчлөө арилгах боломж олгохыг хүсэж, өргөдөл холбогдох баримтаа татан авах хүсэлт гаргасны дагуу Улсын дээд шүүхийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 04/1032 дугаар албан бичгээр буцаасан.

Тэрээр алдаа зөрчлөө арилгасан гэх үндэслэлээр 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр өргөдөл гаргасан ба хавсарган ирүүлсэн 801 гишүүний мэдээллийг өмнөх 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 801 гишүүний бүртгэлтэй тулгаж үзэхэд, 12 гишүүн хасагдаж, тэдгээрийн оронд шинээр 12 гишүүн бүртгэгдсэн. Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээллийн зөрчилтэй 139 гишүүний 3 нь хасагдаж, 136 гишүүний мэдээлэл засагдсан байдлаар ирсэн тул шүүхээс шинээр ирсэн 12 гишүүн, мэдээллийн зөрүүтэй 136, нийт 148 гишүүний мэдээллийг 2023

оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газарт файл болон цаасан хэлбэрээр хүргүүлж, улмаар тус газрын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 4/3353 дугаар албан бичгээр “нийт 148 иргэнээс 3 иргэний хаягийн мэдээлэл /баг, хороо ... / зөрүүтэй” байдал тогтоогдсон хэдий ч энэхүү 3 иргэний хаягийн мэдээллийн зөрүүтэй байдлыг зөрчилд тооцохооргүй байна.

Тодруулбал, Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Улсын дээд шүүх дараах үндэслэлээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана” гээд 10.1.3-т “гишүүдийн тоо нь энэ хуулийн 9.3.7-д заасан тоонд хүрээгүй буюу бүртгэлд орсон гишүүн нь өөр намын харьяалалтай, эсхүл өөр хүн төлөөлсөн” гэж заасан татгалзах үндэслэлд 3 иргэний хаягийн зөрүүтэй байдал нь шууд хамаарах, татгалзах нөхцөл биш гэж үзлээ.

Нөгөөтэйгүүр, өмнөх 39 дүгээр тогтоолд дурдсан намын гишүүн биш гэсэн 19 иргэнээс 17 иргэний нэрс нь 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн өргөдөлд хавсарган ирүүлсэн 801 гишүүний бүртгэлд бичигдэж ирээгүй, үлдсэн 2 /Д.Аминь, Б.Бөхсүрэн/ нь гишүүний бүртгэлд бүртгэгдсэн бөгөөд эдгээр нь өмнөх түүврийн аргаар авсан судалгаанд “намын гишүүн биш” гэж хариулж байсан боловч шүүхэд бичгээр ирүүлсэн тайлбартаа “тухайн намын гишүүн мөн” гэж тодорхойлон холбогдох баримтаа ирүүлсэн тул шүүхээс тэднийг намын гишүүн биш гэх үндэслэл тогтоогдсонгүй.

Дөрөв. Улс төрийн намын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Намын дотоод зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог намын дүрмээр зохицуулна” гээд 11.2-т “Намын дүрэмд дараахь нийтлэг зүйлийг тусгана: /11.2.1-11.2.9/ гэж, 13 дугаар зүйлд Намын байгууллагын талаар зохицуулжээ.

Тус намын дүрэм, үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгахад зөрчилтэй байдал тогтоогдсонгүй. Тодруулбал:

а/ Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоолоор “... Улс төрийн намын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.4-т заасан “анхан шатны байгууллагыг байгуулах тухай” асуудал тус намын дүрэмд тусгагдаагүй, ... хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5-д “намын Их болон бусад хуралд төлөөлөгч сонгох, оролцох, удирдах болон хяналтын байгууллага байгуулах, тэдгээрийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны тухай” намын дүрэмд заавал тусгахаар зохицуулсныг зөрчсөн, ... хуулийн 13 дугаар зүйлийн 13.8-д “Намын орон нутгийн төлөөллийн байгууллагыг нууц санал хураалтаар сонгож байгуулна” гэж заасан шаардлага хангагдаагүй. Энэ талаар дүрэмд тусгагдаагүй, дүрмийн 18.1-д “Намын үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэрийг Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу зөвхөн намын Их хурал гаргах ба уг шийдвэрийн талаар ажлын 10 хоногт багтаан Улсын дээд шүүхэд мэдэгдэнэ” гэсэн нь ... хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Нам үйл ажиллагаагаа намын эрх барих дээд байгууллагын шийдвэрээр зогсоох бөгөөд ажлын 5 өдөрт багтаан Улсын дээд шүүхэд энэ тухай бичгээр мэдэгдэнэ ...” гэж заасантай нийцээгүй, ... дүрмийн 13.2-т “НДШБ-н Дүрэм ёс зүйн хороо нь энэ дүрмийн 14.1-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасан боловч дүрмийн 14.1-д “Дүрэм ёс зүйн ерөнхий хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан мөн” гэсэн өөр агуулга бүхий зохицуулалт байна” гэж Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дүрэм “хуульд харшилсан” үндэслэлээр уг намыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж байсан.

Энэхүү алдаа зөрчлийг 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн нам үүсгэн байгуулах Их Хурлаас дараах байдлаар зассан байна.

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дүрэмд:

1.5.4. Намын бүх шатны сонгуульт байгууллагад эмэгтэйчүүдийн оролцоог хангана.

1.6.1. Монгол Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох;

1.6.4. Хуульд өөрөөр заагаагүй бол үйл ажиллагааныхаа зохион байгуулалтын бүтэц, зорилт, арга хэлбэрээ чөлөөтэй сонгох;

6.6.10. Намын төлөөллийн төв байгууллага, намын хяналтын төв байгууллагыг сонгож байгуулахдаа тэдгээрийн гишүүдийг нууц санал хураалтаар сонгох бөгөөд улиран сонгогдож болно.

6.7. Намын их хуралдаан нь ээлжит болон ээлжит бус байна. Хуралдааны дэгийг тухайн хурал өөрөө тогтооно.

Арван хоёрдугаар бүлэг. Намын хяналтын байгууллага, бүтэц, зохион байгуулалт.

12.1. ... намын хяналтын төв байгууллага нь Дүрэм, ёс зүйн ерөнхий хороо мөн.

Арван гуравдугаар бүлэг. Намын хяналтын байгууллагын эрх, үүрэг.

13.17. Дүрэм, ёс зүйн ерөнхий хороо, салбар хорооны үйл ажиллагаа, шийдвэр гаргах үйл ажиллагаа, бусад эрх үүргийг журмаар зохицуулна.

Арван дөрөвдүгээр зүйл. Намын анхан шатны байгууллага.

14.2. Намын анхан шатны байгууллагыг тухайн сум, дүүрэг, баг, хороонд харьяалагдах намын бүх гишүүдийн хурлаас байгуулах бөгөөд сум, дүүрэгт намын хороо, баг, хороонд намын үүр байна.

14.6.1. Баг, хорооны намын үүрийн даргыг оруулан нийт 5 тэргүүлэгчдээс бүрдсэн намын үүрийг байгуулна. /баг, хорооны намын байгууллага, даргыг жишээ нь: “Төв аймгийн Батсүмбэр сумын 1-р багийн Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам /САИН нам/-ын үүр, үүрийн дарга” гэж, “Баянгол дүүргийн 33-р хорооны Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам /САИН нам/-ын үүр, үүрийн дарга” гэж тус тус нэрлэнэ/;

14.8.3. Аймаг, нийслэлийн намын бүх гишүүдийн ээлжит хурал товлон зарлагдсан тохиолдолд төлөөлөгч сонгох бол;

Арван тавдугаар бүлэг. Намын дунд шатны байгууллага.

15.4.3. Намын Их Хурал товлон зарлагдсан тохиолдолд төлөөлөгч сонгох бол;

15.5. Намын дунд шатны байгууллага нь дараах эрх, үүрэгтэй байна. /15.5.1-15.5.16/

19.1. Намын үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэрийг Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу зөвхөн намын Их Хурал гаргах ба уг шийдвэрийн талаар ажлын 5 өдөрт багтаан Улсын дээд шүүхэд мэдэгдэнэ; гэжээ.

б/ Мөн Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 20 дугаар тогтоолоор “... намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах журам, намыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай журмыг тус тус нарийвчлан зохицуулаагүй байх тул уг дүрэм нь хуулийн 11 дүгээр

зүйлийн 11.2.5, 11.2.6-д нийцсэн гэж үзэхгүй, ... намын санхүүжилтийн талаар зохицуулсан хуулийн холбогдох заалтууд нарийвчлан зохицуулагдаагүй, ... нэр дэвшигчийг эцэслэн батлах намын Их Хурал болон намын төлөөллийн төв байгууллага болох намын Бага хурал нууц санал хураалтаар шийдвэрлэх талаар нарийвчлан заагаагүйгээс гадна мөн дүрмийн 1.6.4 дэх заалтын дагуу тодруулна гэсэн ч уг заалт тус намын дүрэмд байхгүй байна, ... хуулиар гагцхүү намын Их Хуралд олгосон “намын төлөөллийн төв болон хяналтын төв байгууллагын тайланг хэлэлцэх” эрхийг баталгаажуулаагүй, ямар нөхцөл, шаардлагын үүднээс намын үйл ажиллагааг зогсоох үндэслэл бүрдэх, түүнийг зохицуулсан журам байхгүйгээс гадна намын Их Хурал, түүний эрх шилжүүлснээр намын Бага хурлаас шийдвэрлэх “намын хяналтын байгууллагын бүрэлдэхүүнийг сонгох, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах” эрхийг өөр этгээд хэрэгжүүлэхээр дүрмийн 33.3-т ... заасан нь хуульд харшилж байна, ...” гэж Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дүрэм “хуульд харшилсан” үндэслэлээр уг намыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсаныг доорх байдлаар зассан байна.

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дүрэмд:

6.6.Намын Их Хурал нь бодлогын үндсэн асуудлыг хэлэлцэн, онцгой бүрэн эрхийн хүрээнд дараах асуудлыг шийдвэрлэнэ:

6.6.3.Намын даргын бүрэн эрхийн хугацааны тайланг хэлэлцэх;

6.6.4.Бага хурлын гишүүдийг сонгож байгуулах, бүрэн эрхийн хугацааны тайланг хэлэлцэх;

6.6.5.Дүрэм, ёс зүйн ерөнхий хорооны бүрэлдэхүүнийг сонгох, бүрэн эрхийн хугацааны тайланг хэлэлцэх;

7.2.Намын Бага хурал нь дараах эрх, үүрэгтэй байна:

7.2.3.САИН намаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон УИХ-ын сонгуульд нэр дэвшүүлэх нэр дэвшигчийг хэлэлцэх, нууцаар санал хурааж батлах;

7.2.9.Намын Их хурлын чөлөөт цагт намын дүрэм, мөрийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах асуудлыг Бага хурлын хурлын гишүүдийн гуравны хоёроос багагүй гишүүдийн саналаар шийдвэрлэн батлах. (Энэхүү өөрчлөлт нь намын бүтэц, зохион байгуулалттай холбоотой болон намын дотоод ардчилал, эв нэгдэлд сөргөөр нөлөөлсөн, гишүүдийн эрх тэгш байдлыг алдагдуулсан, эрхийг хязгаарласан байхыг хориглоно);

7.2.11.Намын Их Хурлын чөлөөт цагт намын Бага хурлын бүрэлдэхүүнд сул орон гарвал нөхөн сонгох, батлах, Дүрэм ёс зүйн ерөнхий хорооны бүрэлдэхүүнд сул орон гарвал батлах;

7.2.17.Намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах журмыг боловсруулан хэлэлцэн батална;

8.3.1.Намын дарга санхүү, төсвийн үйл ажиллагаанд захиран зарцуулах, эрхтэйгээр оролцохыг хориглоно;

8.3.3.Намын Их хурлын чөлөөт цагт намын Бага хурлын гишүүний сул орон гарсан тохиолдолд намын бага хурлын гишүүнийг нөхөн сонгуулах саналыг бага хуралд оруулан хэлэлцүүлэн батлуулах;

8.3.13.Тухайлсан тойрогт УИХ-ын ээлжит болон нөхөн сонгуульд нэр дэвшигчийг өөрчлөх бол намын Бага хурлаар хэлэлцүүлэх;

12.4.Дүрэм, ёс зүйн ерөнхий хороо нь намын Их хурлаас 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр дараагийн Их Хурал хүртэл, салбар хороо нь аймаг, нийслэлийн намын бүх гишүүдийн хурлаас 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр дараагийн бүх гишүүдийн хурал хүртэлх хугацаагаар тус тус нууц санал

хураалтаар сонгогдоно.

Арван долоодугаар бүлэг. Намын хөрөнгө, орлого, түүнийг зарцуулах журам
17.1.Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу намын хөрөнгө нь хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, мөнгөн хөрөнгөөс бүрдэх ба дараах зүйлс намын хөрөнгө, орлогод хамаарна: гээд 17.1.1-17.119-д заасан/ гэж оруулсан байна.

Тав. Улс төрийн намын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Нам нь Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, үндэсний эрх ашигт нийцсэн өөрийн үзэл баримтлал, үйл ажиллагааны зарчим, эрхэм зорилго, тэдгээрийг хэрэгжүүлэх үндсэн арга замыг тодорхойлсон мөрийн хөтөлбөртэй байна” гэж тус тус тусгасан байна.

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын үүсгэн байгуулах Их Хурлын Төлөөлөгчдийн (анх) 2021 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 07 дугаар тогтоолоор намын мөрийн хөтөлбөрийг баталж, зорилгоо “... хүн төрөлхтний нийтлэг хөгжлийн чиг хандлагыг эрхэмлэн ардчилсан Үндсэн хуулийн суурь зарчмуудыг хамгаалж, Монгол Улсын ирээдүйн төлөө үзэл санаандаа үнэнч, хүн ардаа гэсэн цайлган сэтгэлтэй, ухаарч сэтгэх чадвартай, уужим талибуун сэтгэлгээтэй гишүүдээр намаа бүрдүүлэн, ардчиллыг баталгаажуулахын төлөө зогсож, хүний эрх, эрх чөлөө, эрүүл аюулгүй орчинд амьдрах хүний эрхийг хангаж, ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг, ард иргэдийнхээ нийгэм эдийн засгийн баталгааг хангахыг тууштай хөхүүлэн дэмжих ...” гэж тодорхойлжээ.

Улмаар Монгол Улсад байгаль экологи, инновацад суурилсан өндөр бүтээмжтэй аж үйлдвэр, эрчимжсэн технологид тулгуурласан хөдөө аж ахуй, олон зуунаар дасан зохицсон уламжлалт мал аж ахуй, байгалийн шавхагдашгүй нөөцөд суурилсан нөхөн сэргээгдэх эрчим хүч, цогц сүлжээгээр холбогдсон орчин үеийн зам харилцаа, бүрэн шийдэгдсэн дэд бүтэц бүхий барилгажуулалт, төрийн бодит оролцоогоор дэмжигддэг жижиг дунд үйлдвэрлэл, бичил бизнес, хувиараа хөдөлмөр эрхлэлт зэрэг олон талт бодлогуудыг жигд хэрэгжүүлэн экологийн баримжаат эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах бодлогыг тууштай баримтлан хэрэгжүүлэхийг “Монголын тулгуур есөн сайн” хөтөлбөрийг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Сайн хөтөлбөр нэг. Хөдөө аж ахуй, Аж үйлдвэрлэлийн бодлого;
- Сайн хөтөлбөр хоёр. Эдийн засгийн бодлого;
- Сайн хөтөлбөр гурав. Нийгмийн хамгааллын бодлого;
- Сайн хөтөлбөр дөрөв. Эрүүл мэндийн бодлого;
- Сайн хөтөлбөр тав. Дэд бүтцийн бодлого;
- Сайн хөтөлбөр зургаа. Хууль зүйн бодлого;
- Сайн хөтөлбөр долоо. Боловсрол, соёл, шинжлэх ухааны бодлого;
- Сайн хөтөлбөр найм. Батлан хамгаалах бодлого;
- Сайн хөтөлбөр ес. Гадаад бодлого; гэж зааж, түүнийг хэрэгжүүлэх арга замаа тодорхойлжээ.

Тус намын мөрийн хөтөлбөр нь Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т заасан “Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг бусниулах, үндэсний эв нэгдлийг задлан бутаргах, Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, олон түмнийг үймүүлэх, айлган сүрдүүлэх, аллага, хядлага үйлдэх, яс үндэс, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, бусад орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, сурталчилгаа явуулах зорилгоор, түүнчлэн шашны, цэргийн болон цэрэгжсэн, фашист нам байгуулахыг хориглоно” гэж заасныг зөрчөөгүйгээс гадна Улсын дээд

шүүхийн нийт шүүгчийн 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 20, 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 30, 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 39 дүгээр тогтоолуудаар тус намын мөрийн хөтөлбөрийг хууль зөрчсөн талаар дүгнээгүй болохыг дурдах нь зүйтэй.

Зургаа. Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын дарга Б.Жагараас 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр тухайн хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтыг хийлгэж, өргөдөлд хавсарган ирүүлсэн нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.3-т заасны дагуу намын нэрийг баталгаажуулсан гэж үзнэ.

Тус намын бүтэн нэр нь Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам, товчилсон нэр нь “САИНН” нам гэж дүрэмдээ тусгасан нь улс төрийн намыг улсын бүртгэлд бүртгэхэд “нам оноосон нэртэй байх”, “намын бүтэн болон товчилсон нэр нь байгууллага, аж ахуйн нэгж болон бусад намын нэртэй адил байхгүй байх” талаар Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага зөрчигдөөгүй, нэрийн давхцал байхгүй тул энэ нэрээр улс төрийн нам байгуулах нь “хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй” гэсэн Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т заасан шаардлагад нийцжээ.

Дээрхээс дүгнэхэд, Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дүрэм, мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд харшилсан агуулгагүй, намын үйл ажиллагааны зарчим, зорилго, үзэл баримтлал нь Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т заасныг зөрчөөгүй, түүнчлэн өмнөх Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоолд дурдсан зөрчлийг арилгаж, Улс төрийн намын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2-т заасан шаардлагыг хангасан байна.

Иймд, Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д зааснаар намыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах үндэслэл тогтоогдоогүй тул Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ыг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгох үндэслэлтэй гэж Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дүгнэв.

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН) нь мөрийн хөтөлбөр, намын дүрмээ хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль, бусад хууль тогтоомжийг зөрчихгүйгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн үйл ажиллагаа явуулах үүрэгтэй болохыг тэмдэглэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.6-д заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ыг улсын бүртгэлд бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ олгосугай.

2.Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ыг улсын бүртгэлд бүртгүүлснээр Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн үйл ажиллагаа явуулах эрхтэй болсныг дурдсугай.

3.Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг дээдлэн сахиж ажиллахыг Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (Б.Жагар)-д даалгасугай.

4.Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ыг улсын бүртгэлд бүртгүүлсэн болохыг нийтэд мэдээлсүгэй.

5.Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 (нэг зуун тавин мянга) төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

М.БАТСУУРЬ